



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 08 сарын 11 өдөр

Дугаар #/63

Амардалай

Г Малын гоц халдварт өвчин гарсантай
холбогдуулан пост байгуулж ажиллах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа Нутаг Дэвсгэрийн Нэгж Түүний Удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" заалт, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8, 10 дугаар зүйлийн 10.1.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.2, аймгийн Засаг даргын 2017 оны А/260 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Гурван сайхан сумын "Цагаан хошууны хүрээ дээрс"-т, Өлзийт сумын Дэрт-2, Буюнт 1, 2-р баг, Сайнцагаан сумын Алтатын цохио гэх газруудад малын гоц халдварт шүлхий өвчин гарсан нь оношлогдсон тул дээрх сумдаас мал, хүн, машин техникийн шилжилт хөдөлгөөнийг нутаг дэвсгэрээр дайран өнгөрүүлэхийг хориглосугай.

Хоёр: Малын гоц халдварт өвчин гарсан бүс нутгаас ирж байгаа иргэд, малын хөдөлгөөн, тээврийн хэрэгжлийд үзлэг шалгалт, халдвартгүйжүүлэлт хийж, хяналт тавьж ажиллахыг МЭҮТ-ийн дарга Д.Наранцэцэг/, хэсгийн цагдаа /Б.Галсанжав/, "Дэлгэрбаяндалай" ХХК мал эмнэлгийн их эмч /Т.Нарангэрэл/ нарт үүрэг болгосугай.

Гурав: Постонд ажиллах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

Дөрөв: Дээрх үйл ажиллагаанд шаардагдах бензин шатахуун, багаж хэрэгсэл, ариутгал бодис, бусад шаардагдах хөрөнгийн зардлын тооцоог гаргаж, шийдэрлэж ажиллахыг ЗДТГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч /С.Нарантунгалаг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ИШ-ЁНДОН

